

## МОНГОЛЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТАТВАРЫН ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГАА

### Агуулга

1. Өмнөтгөл
2. Судалгааны зорилго ба аргачлал
3. Монгол улсын татварын эрх зүйн орчны товч танилцуулга
4. ТББ-ын татварын өнөөгийн эрх зүйн орчин
5. Татвар төлөгч ТББ-ын бүртгэл
6. ТББ-ын татвар төлөлт
7. Бусад анхаарах зүйлс
8. Дүгнэлт
9. Хавсралт

### ӨМНӨТГӨЛ

**Ардчиллын Боловсрол Төв (ДЕМО)** нь байгуулагдсан цагаасаа Монголын төрийн бус байгууллага (ТББ)-уудын чадавхийг бэхжүүлэх ажлыг өөрийн үйл ажиллагааны үндсэн нэг чиглэл болгон энэ талаар тодорхой үйл ажиллагаа (сургалт, хурал зөвлөгөөн, судалгаа, зөвлөгөө, он-лайн мэдээллийн үйлчилгээ, ТББ-ын сүлжээ уулзалт, хэвлэн нийтлэл, г.м.)-г хэрэгжүүлсээр ирсэн юм.

ТББ-ын үйл ажиллагааны үр дүн болоод тогтвортой байдал нь татварын тогтолцооноос ихээхэн хамааралтай байдаг. ТББ нь улс орны хэмжээнд тулгамдсан асуудлуудыг өөрсдийн оюун санаа, итгэл үнэмшлээрээ шийдвэрлэхээр эвлэлдэн нэгдэж, төсвөөс дэмжлэг тусалцаа авалгүйгээр ашгийн төлөө бус, зөвхөн үүсгэн байгуулагдсан зорилгоо хэрэгжүүлэх зардлыг нөхөх үүднээс нийгмийн сайн сайхны тусын тулд ажиллаж, түүнээсээ зохих хуулийн дагуу татвар төлж байдгаараа бусад татвар төлөгчөөс өвөрмөц онцлогтой.

Монгол Улсын ТББ-ын тухай хууль 1997 онд анх батлагдсан бөгөөд үүнээс хойш 15 жилийн хугацаанд гарч буй нийгмийн өөрчлөлт, ТББ-ын хөгжил дэвшлийг эрх зүйн актуудад уялдуулан шинэчлэн боловсронгуй болгох зорилгоор Нийтэд ач тустай үйл ажиллагааны тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгийн газрын дэргэд байгуулагдаад ажлаа эхлүүлээд байна. ДЕМО нь “Нийтэд ач тустай үйл ажиллагааны тухай хууль”-ийн Ажлын хэсгийн гишүүн бөгөөд энэхүү хуулийн төсөл болон холбогдох татварын актуудад ТББ-ын татварын эрх зүйн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгон тусгах үүднээс “Монголын Төрийн бус байгууллагын татварын өнөөгийн байдал” дүр зургийн судалгааг Олон улсын ашгийн төлөө бус хуулийн төвийн санхүүжилтээр хийж гүйцэтгэв.

Судалгааны тоон үр дүнгээс товчлон дурьдахад:

- 2011 оны байдлаар МУ-ын хэмжээнд татварын албадад нийт 3.329 иргэний нийгмийн байгууллага бүртгэлтэй байна.
- Дээрх 3.329 ТББ-аас Улаанбаатар хотод 2.554 ТББ бүртгэлтэй байгаа нь дийлэнх буюу 76,7 хувийг эзэлж байна. Үлдсэн 775 ТББ буюу 23,3 хувь нь аймгийн татварын албанд хамрагдаж байна.
- Улаанбаатар хотын 8 дүүрэгт татварын албанд бүртгэлтэй нийт 2.554 байгууллага байгаа ба үүнээс 813 олон нийтийн байгууллага, 123 сан, 1.618 төрийн бус байгууллага байна.
- Нийслэлийн хэмжээнд Сүхбаатар дүүрэгт 763, Баянгол-481 ТББ, Баянзүрх-468 тус тус бүртгэлтэй байгаа нь тухайн дүүргүүд хамгийн олон ТББ-тайд тооцогдож байна.
- Аймгуудын татварын албанд бүртгэлтэй 775 байгууллагаас олон нийтийн байгууллага нь 325, сан 35, төрийн бус байгууллага 415 байна. Аймгуудын татварын албанд Дархан-

Уул-101, Орхон-89, Дорноговь-80 ТББ бүртгэгдсэнээр бусад амгуудаас дийлэнх байр суурийг эзэлж байна.

- 2009-2011 онуудад ТББ-ууд нийт дүнгээр 16,6 тэрбум төгрөгийн татвар төлсөн байна.
- ТББ-ын татвар төлөлтийн татварын төрлүүдээс хамгийн их төлөгддөг татвар нь цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого бөгөөд энэ нь нийт татварын дүнгийн 78,9%-ийг эзэлж байна. Үүний дараагаар үл хөдлөх хөрөнгийн татвар 6,6%, дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ 6,3%, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар 4,6% зэрэг татварын хэлбэрүүд тус тусын хувьтай байна.

## СУДАЛГААНЫ ЗОРИЛГО БА АРГАЧЛАЛ

### Судалгааны зорилго

Монголын Төрийн бус байгууллагын татварын төлөв байдлын судалгааны зорилго нь Монголын ТББ-уудын төлж буй татварын төрөл, хэмжээ, хэлбэрийг сүүлийн 3 жил (2009-2011)-ээр гаргаж ТББ-ын татварын эрхзүйн орчныг цаашид боловсронгуй болгоход шаардлагатай дүгнэлт, зөвлөмжийг тодорхойлоход оршино.

### Судалгааны аргачлал

- ТББ-ын татварын эрх зүйн актуудын дүн шинжилгээ: ТББ-ын татварыг зохицуулж буй өнөөгийн эрх зүйн актууд, батлагдсан огноо, орсон нэмэлт, өөрчлөлт, зохицуулалт.
- ТББ-ын татварын тоон мэдээлэллийн дүн шинжилгээ: Монгол улсын татварын албадад бүртгэлтэй ТББ-ын тоо, хариуцлагын хэлбэр, ТББ-ын төлдөг татварын төрөл, хэмжээ, нийслэл болон орон нутгийн ТББ-аар.
- Төрийн болон төрийн бус байгууллагын холбогдох ажилтнуудтай уулзалт, ярилцлага: ТББ-ын татварын орчин ямар түвшинд байна хэмээн үнэлж байна вэ, ТББ-ын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байна вэ, татварын орчны өнөөгийн байдлыг сайжруулахад юу хийх хэрэгтэй вэ, төрийн зүгээс ямар дэмжлэг хэрэгтэй байна, г.м.

Монголын Төрийн бус байгууллагын татварын төлөв байдлын судалгааны агуулга, багтаамж, аргачлал болон дүн шинжилгээг Ардчиллын Боловсрол Төвийн судлаачдын баг боловсруулан гүйцэтгэв. Судалгаанд хэрэглэгдэх тоо баримт, суурь мэдээллийг цуглуулахад МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгийн газар болон Татварын ерөнхий газрын Мэдээлэл, статистикийн хэлтсийн холбогдох ажилтан, албан тушаалтнууд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан. Энэ судалгааг Татварын Ерөнхий Газраас авсан 2009-2011 оны ТББ-ын мэдээлэлд тулгуурлан гаргав. Үүнээс гадна Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Үндэсний статистикийн хорооноос ТББ-ын бүртгэл, үйл ажиллагаатай холбогдолтой мэдээллийг мөн давхар судлаж харьцуулсан болно.

Татварын албадад бүртгэлтэй ТББ-ын тоон мэдээллийг Татварын ерөнхий газраас авсан бөгөөд 2011 оны 12 сарын 31-ний байдлаар 3,329 ТББ татварын албадад бүртгэлтэй байв.

## МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол улс татварын шинэчлэлийг 1993 оноос хойш 4 удаа хийсэн бөгөөд шат дараалан татварын шатлал, түвшинг бууруулсан байна. МУ-ын УИХ-аас 2006 оны 6 дугаар сард Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар, Хувь хүний орлогын албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвар болон Онцгой албан татварын шинэчлэн найруулсан хуулийн төслүүдийг тус тус батлаж 2007 оноос даган мөрдөж байна. Засгийн газраас 2007 онд татварын шинэчлэлээр аж ахуйн нэгж, байгууллагын татварын ачааллыг бууруулах бодлого нэвтрүүлсэн бөгөөд татварын шатлал, түвшинг бууруулсан өөрчлөлтийг Хүснэгт 1-ээр харуулж байна.

**Хүснэгт 1. Монгол улсын татварын хувь хэмжээний өөрчлөлт**

Татварын төрөл	1993-1997 он	1997-2001 он	2001-2004 он	2004-2006 он	2007 оноос хойш
Хүн амын орлогын албан татвар	5 шатлалтай 0.2%, 15%, 27%, 40%	3 шатлалтай 10%, 20%, 40%		3 шатлалтай 10%, 20%, 30%	1 шатлалтай 10%
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	4 шатлалтай 15%, 25%, 35%,40%	2 шатлалтай 15%, 40%		2 шатлалтай 15%, 30%,	2 шатлалтай 15%, 25%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	5%	10%	15%	15%	10%, 0%

**Хувь хүний орлогын албан татварын тухай хууль**

УИХ-аас Хүн амын орлогын албан татварын хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2006 оны 6 дугаар сарын 16-ны өдөр батласан бөгөөд 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн даган мөрдөж байна.

- Хүн амын орлогын албан татварыг 2007 оноос өмнө мөрдөгдөж байсан 10, 20, 30 гэсэн хувь хэмжээг 10 хувь болгон өөрчилж, шатлалгүй болгосон.
- Иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх зорилгоор жилийн татварын хөнгөлөлтийн хэмжээ 48,000 төгрөг байсныг 84,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн. Өөрөөр хэлбэл сарын 144,000 төгрөгөөс бага орлоготой иргэд хувь хүний орлогын албан татвар төлөхгүй гэсэн үг юм.

**Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль**

Монгол Улсын Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар /ААНБОАТ/ -ын хууль нь 1992 оны 12 дугаар сарын 14-нд батлагдаж 1993.11.03, 1994.07.04, 1997.04.17, 1997.10.30, 1997.12.05, 1998.01.09, 1998.01.15, 1998.11.06, 1999.01.22, 1999.05.12, 2000.02.03, 2000.11.17, 2001.01.25, 2001.11.09, 2002.12.05, 2003.11.27, 2004.04.23, 2006.06.29-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон. 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр УИХ-аар батлагдсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай шинэ хууль нь 2007 оноос эхлэн мөрдөгдөж байна.

- Энэ хуулиар албан татвар ногдуулах орлогын шатлалын доод хэмжээ 100.0 сая төгрөг байсныг 3.0 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлсэн.
- 3,0 тэрбум төгрөгнөөс дээш албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 300,0 сая төгрөг дээр 3,0 тэрбум төгрөгнөөс дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж албан татвар ногдуулах болсон.
- Энэ хуулиар ТББ-ыг татвар төлөгч биш болгож хасаж 2007 оноос өмнө үйлчилж байсан ТББ-ын татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хүчингүй болгосон.
- Мөн энэ хуульд 2007 оны 8 сарын 3-ны өдрийн хуулиар 19.10 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагыг дэмжих зорилгоор аж ахуйн нэгж, иргэнээс хандивласан нэг сая хүртэлх хэмжээний төгрөгийг ийнхүү хандивласан болох нь тогтоогдсон тохиолдолд тухайн татварын жилд уг аж ахуйн нэгжийн албан татвар ногдох орлогоос хасч тооцно” гэсэн заалтыг нэмсэн.

- Энэ хуулийн 17.2.9-ийн заалтын дагуу Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч Монгол Улсын нутаг дэвсгэр дээр борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний орлого; эрхийн шимтгэлийн орлого, санхүүгийн түрээсийн хүүгийн орлого, удирдлагын зардалд төлсөн төлбөр, түрээсийн төлбөр, биет болон биет бус хөрөнгө ашиглуулсны орлого; зээлийн хүүгийн болон батлан даалт гаргасны төлбөр; Монгол Улсад бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээс авсан ногдол ашгийн орлогод 20 хувиар алба татвар ногдуулна гэж заасан байна.

#### **Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль**

УИХ-аас Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг шинэчилсэн найруулгаар 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр батлан гаргаж шинээр батлагдсан бусад татварын хуулиудын нэгэн адил 2007 оноос эхлэн дагаж мөрдөж байна.

- Энэ хуулийн 5.1-ийн заалтаар нэмэгдсэн өртгийн албан татварын хувь хэмжээг 15% байсныг 10% болгож бууруулсан.
- Тус хуулийн 13.1-т дараах барааг НӨАТ-аас чөлөөлнө гэж заасан байна:
  - 13.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн үндэсний байгууллага түүний төрөлжсөн салбарын хэрэгцээнд зориулан импортолсон бараа;
  - 13.1.4. Гадаад улсын Засгийн газар, төрийн бус байгууллага, олон улсын болон буяны байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламжаар авсан бараа;
  - 13.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэглээнд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмж, автотээврийн хэрэгсэл.
- Мөн хуулийн 13.6-д дараах үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлнө гэж тусгасан:
  - 13.6.9. Боловсролын болон мэргэжлийн сургалт явуулах тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээдийн эрхлэн гүйцэтгэж байгаа дүрэмд нь заасан боловсрол, мэргэжил олгох үйлчилгээ;
  - 13.7. Жилийн 10.0 сая ба түүнээс доош төгрөгийн борлуулалтын орлоготой үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхлэгчид /импортлогчоос бусад/-ийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө.

#### **Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль**

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль нь 2008 оны 5 сарын 20-ны өдөр батлагдаж тухайн оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж байна. Энэ хуулиар ТББ-ууд нийтийн төлөөх зорилгод хэрэглэхээр импортлосон бараа, үйлчилгээндээ гаалийн татвар болон импортын НӨАТ-ийн татварыг төлнө. Тухайн хуулийн 38 дугаар зүйлийн Гаалийн татвараас чөлөөлөгдөх бараа гэдэгт ТББ-тай холбогдолтой “хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжийн бараа” гэсэн заалт байгаа юм. Гэхдээ энэ нь зөвхөн гадаад улсын засгийн газар болон олон улсын байгууллагын санхүүжилттэй иргэний нийгмийн байгууллагуудад хамаардаг бөгөөд эдгээр татвараас чөлөөлдөг.

2011 онд ТББ-ууд нийтдээ 1,3 тэрбум төгрөгийн гаалийн татвар төлсөн байна. Үүнээс 421,2 сая төгрөгийн гаалийн татвар болон 486,5 сая төгрөгийн импортын НӨАТ-ыг төлжээ /хавсралт № ... үзнэ үү/.

#### **ТББ-ЫН ТАТВАРЫН ӨНӨӨГИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Төрөөс төрийн бус байгууллагыг дэмжих гол механизмын нэг нь татварын таатай бодлого буюу ТББ-уудад үзүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлт байдаг. Дэлхийн ихэнх орнууд ТББ-уудыг татварын таатай бодлогоор дэмждэг бөгөөд орлого, ашгийн татвар, эд хөрөнгийн татвар,

онцгой татвар, нэмэгдсэн өртгийн татвар, гаалийн зэрэг татваруудаас чөлөөлдөг олон улсын нийтлэг стандарт байдаг.

Төрийн бус байгууллагуудыг гишүүддээ үйлчилдэг болон нийгэмд үйлчилдэг гэж хуваадаг нь татвар ногдуулах талаасаа ихээхэн ач холбогдолтой юм. Нийгэмд үйлчилдэг байгууллага нь нийтэд буюу нийгмийн зарим тодорхой хэсэгт ач тустай байхын зэрэгцээ гишүүдийнхээ ашиг сонирхолд үйлчилдэг байгууллагуудтай харьцуулахад төрөөс илүү их дэмжлэг туслалцаа хүртэх эрхтэй байдаг. Иймээс ихэнх орнууд нийтэд ач тустай үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг татвараас бүрэн чөлөөлдөг байна.

Монгол Улсын хувьд 1997 онд батлагдсан ТББ-ын тухай хуулиар төрийн бус байгууллагуудыг гишүүддээ үйлчилдэг болон нийгэмд үйлчилдэг гэж ангилсан бөгөөд уг хуулийн 19-р зүйлд ТББ-ын орлого нь гишүүний татвар, хандив, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого, зээлийн, өвийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө зэргээс бүрдэхээр тодорхойлсон байдаг.

### **Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль**

1992 онд батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулиар албан татвар төлөгч нь гагцхүү ашгийн төлөө байгууллагууд байна гэж заажээ. 1997 оны “Төрийн бус байгууллагын тухай” хуульд төрийн бус байгууллагыг ашгийн төлөө бус байгууллага гэж томъёолж ААНБОАТ-ын 1997 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар “төрийн бус байгууллага нь албан татвар төлөгч байна” гэж заажээ.

2007 оноос өмнө мөрдөгдөж байсан “Аж ахуйн нэгж, байгууллагын албан татварын тухай” хуулийн 7.1.7-д “нийгэмд үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагын орлогыг албан татвараас чөлөөлнө”, мөн 7.1.2-т “төрийн бус байгууллагын гишүүд, дэмжигчдийн татвар, хандивыг албан татвараас чөлөөлнө” гэж тус тус заасан байсан. Мөн түүнчлэн хуулийн этгээдээс ТББ-д өгсөн хандивыг татвараас чөлөөлөлдөг заалт 1997 оны хуулиар батлагдсан байсныг УИХ-аас 1999 онд Татварын хуулиудад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөр энэ заалтыг хүчингүй болгосон юм.

2006 оны 6 дугаар сард батлагдсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар ТББ-ыг татвар төлөгчийн жагсаалтаас хасаж ТББ-ын татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалтуудыг бүгдийг нь хассан. Одоо зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс үүсгэн байгуулсан ТББ-ыг дэмжих зорилгоор аж ахуйн нэгж, иргэнээс хандивласан 1,0 сая хүртэлх хэмжээний төгрөгийг ийнхүү хандивласан болох нь тогтоогдсон тохиолдолд тухайн татварын жилд уг аж ахуйн нэгжийн албан татвар ногдох орлогоос хасч тооцно гэсэн зохицуулалт Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмсэн байдаг.<sup>1</sup>

1997-2006 онд төрийн бус байгууллагын хувьд дараах орлогууд албан татвараас чөлөөлөгдөх заалттай байсан бөгөөд 2007 оноос эхлэн хүчингүй болсон. Үүнд:

- Төрийн бус байгууллагын гишүүд дэмжигчдийн татвар хандив
- Нийгэмд үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагын орлого

Доорх хүснэгтээр 2001-2011 онуудад төрийн бус байгууллагуудын орлогыг албан татвараас чөлөөлөгдсөн байдлыг харуулж байна.

### **Хүснэгт 2. Төрийн бус байгууллагуудын албан татвараас чөлөөлөгдсөн орлогын дүн**

<sup>1</sup> Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19.10 заалт.

/сая.төгрөг/

№	Албан татвараас чөлөөлөгдөх орлого	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011
1	Төрийн бус байгууллагын гишүүд, дэмжигчдийн татвар, хандив	252	45.4	104	682	631	888	Хуулийн заалт хүчингүй болсон.				
2	Нийгэмд үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагын орлого	83.2	379	59.3	1.191	903	991					
3	Хараагүй ажилтан ажилладаг аж ахуйн нэгжийн орлого	Тухайн онуудад хуулийн заалт байгаагүй						-	-	-	0.7	-
4	ААНОАТ-ын хуулийн 19-р зүйлийн 8 дахь хэсгийн дагуу							359	445	41.4	45.1	291
5	ААНОАТ-ын хуулийн 19-р зүйлийн 10 дахь хэсгийн дагуу							-	-	-	76.1	-

Бусдаар ТББ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн дагуу холбогдох татварын төлөгч мөн юм.

### ТАТВАР ТӨЛӨГЧ ТББ-ЫН БҮРТГЭЛ

2011 оны байдлаар МУ-ын хэмжээнд татварын албадад нийт 3.329 иргэний нийгмийн байгууллага бүртгэлтэй байна. Ардчиллын боловсрол төвөөс 2005 онд хийсэн ТББ-ын татварын судалгаагаар нийт 1.042 ТББ бүртгэгдсэн байсантай харьцуулвал 6 жилийн дотор татвар төлөгч ТББ-ын тоо 2.287-оор өссөн байна. Энэ нь 2006 оноос хойш жилд дунджаар 380 /сард ойролцоогоор 30/ ТББ татварын албанд бүртгүүлж байсан гэсэн зураглал гарч байна.

#### ТББ-ын бүртгэл: тоо, хариуцлагын хэлбэрээр

МУ-ын татварын албадад бүртгэлтэй ТББ-ыг тоо, хариуцлагын хэлбэрийг доорхи хүснэгтээс үзэхэд МУ-ын татварын албанд ТББ-ыг хариуцлагын 3 хэлбэрээр бүртгэдэг бөгөөд үүнд Олон нийтийн байгууллага, Сан болон Төрийн бус байгууллага гэж тус тус бүртгэсэн байна. Мөн дөрөв дэх хэлбэр гээд 343 шашны байгууллага бүртгэлтэй байна. 1997 оны ТББ-ын тухайн хуулиар ТББ-ыг холбоо, сан, нийгэмд үйлчилдэг, гишүүддээ үйлчилдэг гэж ангилдаг хэдий ч энэ ангиллыг татварын албад дээрх 3 хэлбэрээр бүртгэсэн байгаа нь ТББ-ын бүртгэлийг цэгцлэх,

мөн ангиллын нэгдсэн стандартыг холбогдох төрийн бүх байгууллагуудаар жигд мөрдүүлэх шаардлага тулгамдаж байгааг харуулж байна.

### Хүснэгт 3. МУ-ын хэмжээнд татварын албанд бүртгэлтэй ТББ-ын тоо

ТББ-ын хариуцлагын хэлбэр	Татварын албанд бүртгэлтэй байгууллагын тоо
Олон нийтийн байгууллага	1.138
Сан	158
Төрийн бус байгууллага	2.033
Нийт	3.329

### ТББ-ын бүртгэл: тоо, газар зүйн байршлаар /дүүрэг, аймаг тус бүрээр/

МУ-ын хэмжээнд татварын албанд бүртгэгдсэн 3.329 ТББ-аас Улаанбаатар хотод 2.554 ТББ бүртгэлтэй байгаа нь дийлэнх буюу 76,7 хувийг эзэлж байна. Үлдсэн 775 ТББ буюу 23,3 хувь нь аймгийн татварын албанд хамрагдаж байна.

Улаанбаатар хотын 8 дүүрэгт татварын албанд бүртгэлтэй нийт 2.554 байгууллага байгаа ба үүнээс 813 олон нийтийн байгууллага, 123 сан, 1.618 төрийн бус байгууллага байна /хүснэгт 4/.

### Хүснэгт 4. УБ хотын дүүргийн татварын алба дахь ТББ-ын бүртгэл хариуцлагын хэлбэрээр

Д/д	Татварын алба	Хариуцлагын хэлбэр	Татвар төлөгчийн тоо	Нийт
1	Багануур	Олон нийтийн байгууллага	2	26
		Сан	2	
		Төрийн бус байгууллага	22	
2	Баянгол	Олон нийтийн байгууллага	188	481
		Сан	23	
		Төрийн бус байгууллага	270	
3	Баянзүрх	Олон нийтийн байгууллага	131	468
		Сан	18	
		Төрийн бус байгууллага	319	
4	Налайх	Олон нийтийн байгууллага	14	25
		Сан	1	
		Төрийн бус байгууллага	10	
5	Сүхбаатар	Олон нийтийн байгууллага	237	763
		Сан	34	
		Төрийн бус байгууллага	492	
6	Сонгинохайрхан	Олон нийтийн байгууллага	69	196
		Сан	7	
		Төрийн бус байгууллага	120	
7	Хан-Уул	Олон нийтийн байгууллага	68	210
		Сан	19	
		Төрийн бус байгууллага	123	
8	Чингэлтэй	Олон нийтийн байгууллага	104	385
		Сан	19	
		Төрийн бус байгууллага	262	
	<b>Нийт</b>	Олон нийтийн байгууллага	813	2.554



	Сан	123	
	Төрийн бус байгууллага	1.618	
	<b>Нийт дүн</b>	<b>2.554</b>	

Нийслэлийн хэмжээнд Сүхбаатар дүүрэгт 763, Баянгол-481 ТББ, Баянзүрх-468 тус тус бүртгэлтэй байгаа нь тухайн дүүргүүд хамгийн олон ТББ-тайд тооцогдож байна.

**Хүснэгт 5. Аймгуудын татварын алба дахь ТББ-ын бүртгэл хариуцлагын хэлбэрээр**

Д/д	Татварын алба	Хариуцлагын хэлбэр	Татвар төлөгчийн тоо	Нийт
1	Архангай	Олон нийтийн байгууллага	5	38
		Сан	0	
		Төрийн бус байгууллага	33	
2	Баян-Өлгий	Олон нийтийн байгууллага	9	20
		Сан	1	
		Төрийн бус байгууллага	10	
3	Баянхонгор	Олон нийтийн байгууллага	11	21
		Сан	1	
		Төрийн бус байгууллага	9	
4	Булган	Олон нийтийн байгууллага	18	27
		Сан	0	
		Төрийн бус байгууллага	9	
5	Говь-Алтай	Олон нийтийн байгууллага	4	22
		Сан	2	
		Төрийн бус байгууллага	16	
6	Говьсүмбэр	Олон нийтийн байгууллага	6	13
		Сан	2	
		Төрийн бус байгууллага	5	
7	Дархан-Уул	Олон нийтийн байгууллага	59	101
		Сан	2	
		Төрийн бус байгууллага	40	
8	Дорноговь	Олон нийтийн байгууллага	45	80
		Сан	2	
		Төрийн бус байгууллага	33	
9	Дорнод	Олон нийтийн байгууллага	24	43
		Сан	1	
		Төрийн бус байгууллага	18	
10	Дундговь	Олон нийтийн байгууллага	4	23
		Сан	0	
		Төрийн бус байгууллага	19	
11	Өвөрхангай	Олон нийтийн байгууллага	16	39
		Сан	2	
		Төрийн бус байгууллага	21	
12	Өмнөговь	Олон нийтийн байгууллага	9	28
		Сан	4	
		Төрийн бус байгууллага	15	
13	Завхан	Олон нийтийн байгууллага	10	50



		Сан	3	
		Төрийн бус байгууллага	37	
14	<b>Орхон</b>	Олон нийтийн байгууллага	41	<b>89</b>
		Сан	4	
		Төрийн бус байгууллага	44	
15	<b>Сүхбаатар</b>	Олон нийтийн байгууллага	6	12
		Сан	1	
		Төрийн бус байгууллага	5	
16	<b>Сэлэнгэ</b>	Олон нийтийн байгууллага	18	41
		Сан	3	
		Төрийн бус байгууллага	20	
17	<b>Төв</b>	Олон нийтийн байгууллага	10	39
		Сан	3	
		Төрийн бус байгууллага	26	
18	<b>Увс</b>	Олон нийтийн байгууллага	12	20
		Сан	1	
		Төрийн бус байгууллага	7	
19	<b>Ховд</b>	Олон нийтийн байгууллага	11	49
		Сан	3	
		Төрийн бус байгууллага	35	
20	<b>Хэнтий</b>	Олон нийтийн байгууллага	7	20
		Сан	0	
		Төрийн бус байгууллага	13	
	<b>Нийт</b>	Олон нийтийн байгууллага	<b>325</b>	775
		Сан	<b>35</b>	
		Төрийн бус байгууллага	<b>415</b>	
	<b>Нийт дүн</b>			<b>775</b>

МУ-ын 20 аймагт татварын албанд бүртгэлтэй 775 байгууллага байна. Үүнээс олон нийтийн байгууллага нь 325, сан 35, төрийн бус байгууллага 415 байна. Аймаггуудын татварын албанд Дархан-Уул-101, Орхон-89, Дорноговь-80 ТББ бүртгэгдсэнээр бусад амгуудаас дийлэнх байр суурийг эзэлж байна. Харин Хөвсгөл аймгийн ТББ-ын бүртгэл ТЕГ-ын мэдээлэлд ороогүй байна.

#### ТББ-ын бүртгэл: ОНБ, сан, ТББ дотор бүртгэгдсэн байгууллагын төрлөөр

Татвар төлөгч ТББ-ууд хариуцлагын 3 хэлбэрээр бүртгэлтэй бөгөөд дотор нь хувааж үзэхэд дараах төрлийн байгууллагууд орсон байна. Үүнд:

#### Хүснэгт 6. ТББ-ын бүртгэл: ОНБ, сан, ТББ дотор бүртгэгдсэн байгууллагын төрлөөр

ТББ-ын хариуцлагын хэлбэр	Улс төрийн нам	Олон улсын, гадаадын байгууллага	Улаан загалмай нийгэмлэг	Үйлдвэрчний эвлэлийн холбоо	Сургууль	Цэцэрлэг	Сонин	СӨХ	Радио, FM	Телевиз	Бусад	Нийт
ОНБ	19	14	17	48	10	9	18	445	1	3	384	968
Сан			1								136	137
ТББ	7	10	72	29	52	28	17	35		4	1.586	1.840
Нийт	26	24	90	77	62	37	35	480	1	7	2.106	2.945

1. Олон нийтийн байгууллага хэлбэрээр бүртгүүлсэн байгууллага дотор Улс төрийн нам 19, Олон улсын/гадаадын байгууллага 14, Улаан загалмай нийгэмлэг 17, Үйлдвэрчний эвлэлийн холбоо 48, Сургууль – 10, Цэцэрлэг 9, Сонин 18, СӨХ 445, Радио ФМ 1, Телевиз 3, Бусад 384 байгууллага тус тус бүртгэгдсэн байна. Бусад гэдэгт Олон нийтийн байгууллага хэлбэрээр бүртгэгдсэн байгууллагууд орж байна.
2. Сан дотор Олон улсын/гадаадын байгууллага нэг байсан бөгөөд энэ нь Нэг Ази нийгэмлэг байна. Бусад нь сан гэсэн бүртгэлдээ багтаж байна.
3. Төрийн бус байгууллага хэлбэрт Улс төрийн нам 7, Олон улсын/гадаадын байгууллага 10, Улаан загалмай нийгэмлэг 72, Үйлдвэрчний эвлэлийн холбоо 29, Сургууль 52, Цэцэрлэг 28, Сонин 17, СӨХ 35, Телевизи 4, Бусад 1.586 тус тус бүртгэгдсэн байна. Бусад гэдэгт ТББ гэсэн хэлбэрээр бүртгэгдсэн байгууллагууд оржээ.

Татвар төлөгч ТББ-ын хэлбэрээр сургууль, цэцэрлэг, сонин, радио, телевиз зэрэг ашгийн төлөө байгууллагууд бүртгэгдсэнээс гадна эрх барьж байсан болон одоо ч засгийн эрхэд байгаа улс төрийн намүүд мөн ТББ-ын хэлбэрээр ажиллаж байна. Дээрхи бүртгэлээс харахад татварын албад дахь ТББ-ын бүртгэлийн тогтолцоог сайжруулах шаардлагатайг дахин нотолж байна.

## ТББ-ЫН ТАТВАР ТӨЛӨЛТ

Энэ хэсэгт ТББ-ын татвар төлөлтийг 2009-2011 онд төлсөн татварын дүн, хариуцлагын хэлбэр, аймаг, дүүрэг, татварын хэлбэр гэсэн үзүүлэлтээр авч үзэв.

### Хүснэгт 7. ТББ-ын татвар төлөлтийн мэдээ оноор

Он	Дүн /мян.₮/	Хувь
2009	4,954,012	29,8%
2010	5,466,098	32,8%
2011	6,222,343	37,4%
Нийт	16,642,453	100%

ТББ-ууд 2009-2011 онд нийт дүнгээр 16,6 тэрбум төгрөгийн татвар төлсөн бөгөөд татвар төлөлтийн байдлыг оноор нь харьцуулж үзэхэд 2009 онд 29,8%, 2010 онд 32,8% тай, 2011 онд 37,4%-ийн үзүүлэлттэй байна. Ингэхдээ татвар төлөлт 2009-2010 оны хооронд 3,0%-иар, 2010-2011 онд 4,6%-иар тус тус өссөн нь ТББ-ын татвар төлөлт жил ирэх тусам тогтвортой өсөлттэй байгааг харуулж байна.

### Хүснэгт 8. ТББ-ын төлсөн татвар хариуцлагын хэлбэрээр, оноор

Хариуцлагын хэлбэр	/мян.₮/				
	2009	2010	2011	Нийт Дүн	Нийт хувь
Олон нийтийн байгууллага	1,827,868	1,966,977	2,193,944	5,988,789	36%
Сан	260,135	283,204	350,825	894,163	5%
Төрийн бус байгууллага	2,866,009	3,215,918	3,677,573	9,759,500	59%
Нийт	<b>4,954,012</b>	<b>5,466,098</b>	<b>6,222,343</b>	<b>16,642,453</b>	<b>100%</b>

Хариуцлагын хэлбэрээр татвар төлөлтийг авч үзэхэд бүгд 3 хэлбэр нь 2009-2011 оны хугацаанд өссөн үзүүлэлттэй байна. Нийт татварын орлогыг нэмэгдүүлэгч гол хариуцлагын хэлбэр нь төрийн бус байгууллага байна.

#### Хүснэгт 9. ТББ-ын татвар төлөлт дүүргээр, оноор

Татварын алба	/мян.₮/				
	2009	2010	2011	Нийт Дүн	Нийт хувь
Багануур	9,917	13,650	18,316	41,883	0.3%
Баянгол	561,679	676,725	721,009	1,959,412	13.0%
Баянзүрх	<b>1,169,752</b>	<b>1,297,465</b>	<b>1,434,482</b>	<b>3,901,699</b>	<b>25.9%</b>
Налайх	15,455	15,439	20,228	51,122	0.3%
Сүхбаатар	<b>1,382,104</b>	<b>1,576,379</b>	<b>1,744,941</b>	<b>4,703,424</b>	<b>31.2%</b>
Сонгинохайрхан	215,213	195,770	216,188	627,171	4.2%
Хан-Уул	377,384	430,179	506,744	1,314,306	8.7%
Чингэлтэй	<b>708,384</b>	<b>787,000</b>	<b>999,487</b>	<b>2,494,871</b>	<b>16.5%</b>
<b>Нийт Дүн</b>	<b>4,439,890</b>	<b>4,992,604</b>	<b>5,661,394</b>	<b>15,093,888</b>	<b>100.0%</b>

Нийслэлийн хэмжээнд Сүхбаатар, Баянзүрх болон Чингэлтэй дүүргийн ТББ-ууд 2009-2011 онуудад төлсөн татварын дүнгээрээ бусад дүүргүүдээ манлайлж байна.

#### Хүснэгт 10. ТББ-ын татвар төлөлт аймгуудаар, оноор, хувиар

Татварын алба	/мян.₮/				
	2009	2010	2011	Дүн	Хувь
Архангай	78,755	62,347	67,509	208,611	7.7%
Баян-Өлгий	18,948	30,888	43,991	93,827	3.5%
Баянхонгор	29,539	19,925	31,129	80,593	3.0%
Булган	32,523	29,038	41,150	102,711	3.8%
Говь-Алтай	35,358	42,208	50,197	127,764	4.7%
Говьсүмбэр	10,994	7,659	13,271	31,924	1.2%
<b>Дархан-Уул</b>	<b>97,044</b>	<b>82,082</b>	<b>108,311</b>	<b>287,437</b>	<b>10.6%</b>
Дорноговь	29,446	32,788	41,973	104,207	3.9%
Дорнод	35,644	44,996	49,944	130,584	4.8%
Дундговь	33,423	27,199	35,203	95,826	3.6%
Өвөрхангай	57,884	52,981	52,484	163,349	6.1%
Өмнөговь	14,590	15,734	20,126	50,450	1.9%
Завхан	51,288	43,480	47,783	142,551	5.3%
<b>Орхон</b>	<b>98,766</b>	<b>109,674</b>	<b>98,647</b>	<b>307,088</b>	<b>11.4%</b>
Сүхбаатар	5,733	3,464	5,514	14,712	0.5%
Сэлэнгэ	30,481	37,352	58,727	126,560	4.7%
Төв	27,718	51,260	62,643	141,621	5.2%
Увс	14,782	18,520	19,129	52,432	1.9%
<b>Ховд</b>	<b>98,104</b>	<b>82,167</b>	<b>104,407</b>	<b>284,678</b>	<b>10.5%</b>
Хэнтий	43,204	56,754	53,478	153,435	5.7%

УИН.МН  
СУДАЛГААНЫ САН

<b>Нийт Дүн</b>	844,226	850,517	1,005,618	2,700,361	100.0%
-----------------	---------	---------	-----------	-----------	--------

МУ-ын 20 аймагт татварын албанд бүртгэлтэй ТББ-уудаас Дархан-Уул, Орхон, Ховд аймгуудын ТББ-ууд 2009-2011 онуудад хамгийн их татвар төлсөн байна.

### Хүснэгт 11. ТББ-ын татвар төлөлтийн татварын хэлбэр, дүн

Татварын төрөл	/мян.₮/				
	2009	2010	2011	Нийт Дүн	Нийт хувь %
Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн татвар	58,670	59,517	55,926	174,112	0.98%
Агаарын бохирдлын төлбөр-АТБӨЯХ эзэмшигч	333,060	495	367	333,922	0.01%
Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	88,720	23,781	24,805	137,306	0.40%
Бусад орлого	587	654	740	1,981	0.01%
Бууны татвар	114	82	119	315	0.00%
Газрын төлбөр	15,736	18,426	17,250	51,412	0.29%
Дотоодын архины онцгой албан татвар			630	630	0.00%
<b>Дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ</b>	<b>331,036</b>	<b>389,727</b>	<b>396,157</b>	<b>1,116,920</b>	<b>6.28%</b>
Дундын суутгал - 3% (Суутган-4)	433	685	1,444	2,563	0.01%
Жишгээр ногдуулсан татвар			72	72	0.00%
<b>Үл хөдлөх хөрөнгийн татвар</b>	<b>338,025</b>	<b>393,788</b>	<b>448,829</b>	<b>1,180,643</b>	<b>6.63%</b>
Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар	14,581	2,860	11,320	28,761	0.16%
Мал бүхий иргэдийн орлого			3	3	0.00%
Нэр заагдаж ангилагдаагүй бусад орлого	147	1,653	1,835	3,636	0.02%
<b>Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар</b>	<b>212,520</b>	<b>253,599</b>	<b>350,013</b>	<b>816,131</b>	<b>4.59%</b>
<b>Татварын хүүгийн орлого</b>	<b>96,245</b>	<b>77,099</b>	<b>114,547</b>	<b>287,891</b>	<b>1.62%</b>
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	100	401	110	611	0.00%
Түрээсийн орлого			195	195	0.00%
Улсын тэмдэгтийн хураамж	2,765	8,640	5,422	16,827	0.09%
Урлаг, тоглолт, спорт тэмцээний, ШУ бүтээл (Суутган-2)			71	71	0.00%
Ус, рашаан ашигласны төлбөр	209	53	1,034	1,297	0.01%
<b>Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого (Суутган-1)</b>	<b>4,189,431</b>	<b>4,611,660</b>	<b>5,236,122</b>	<b>14,037,213</b>	<b>78.89%</b>
Нийт	5,682,377	5,843,121	6,667,012	18,192,510	100%

ТББ-ын татвар төлөлтийн татварын төрлүүдээс хамгийн их төлөгддөг татвар нь цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого бөгөөд энэ нь нийт татварын дүнгийн 78,9%-ийг эзэлж байна. Үүний дараагаар үл хөдлөх хөрөнгийн татвар 6,6%, дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ 6,3%, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар 4,6% зэрэг татварын хэлбэрүүд тус тусын хувьтай байна. Мөн татварын хүүгийн орлого, автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн татвар зэрэг татвар төлөгдөж байна.

### Хүснэгт 12. ТББ-ын ХХОАТ-ын мэдээлэл

/мян.₮/

Татварын төрөл	2009	2010	2011
Төлсөн татвар төлөгчийн тоо	2	5	5
Дундын суутгал - 3% (Суутган-4)	196	34	130
Төлсөн татвар төлөгчийн тоо	337	344	597
Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого (Суутган-1)	2,078,961	2,439,637	3,087,417
<b>Нийт дүн</b>	<b>2,584,217</b>	<b>2,969,570</b>	<b>3,716,054</b>

ТББ-ын Хувь хүний орлогын албан татварын төлөлт жил ирэх тусам өсөж байна.

### Гаалийн татварын төлөлт

2011 онд ТББ-ууд нийтдээ 1,3 тэрбум төгрөгийн гаалийн татвар төлсөн байна. Үүнээс 421,2 сая төгрөгийн гаалийн татвар болон 486,5 сая төгрөгийн импортын НӨАТ-ыг төлжээ. /Хүснэгт/хавсралт?/

### ТББ-ын 2011 онд төлсөн гаалийн татварын мэдээ

№	ТББ-ын нэр	Гаалийн татвар	НӨАТ	Нийт дүн /₮/
1	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим	2,293,974	4,817,344	7,111,354
2	Хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эхчүүдийн холбоо	36,475	76,598	113,074
3	Байгаль орчин консорциум	344,421	723,284	1,067,705
4	Альянс нийгэмлэг ТББ	310,756	652,589	963,345
5	Монгол 21 сан ТББ	485,379	1,430,791	1,916,170
6	Монголын барилгачдын холбоо ТББ	687,210	1,443,141	2,130,354
7	Хүйсийн Тэгш Эрх Төв	136,093	285,796	421,889
8	Монголын чөлөөт бөхийн холбоо	313,660	658,686	972,346
9	Залуу ялагч клуб	49,446	103,837	153,284
10	Монголын волейболын холбоо	51,049,548	107,204	158,254
11	Монголын автомашин мотоциклын холбоо	6,547,100	13,748,910	20,296,010
12	Монголын буудлага спортын холбоо	8,406,273	17,653,172	2,659,445
13	Монголын үндэсний олимпын хороо	1,183,818	2,486,017	3,669,835
14	Монголын сагсан бөмбөгийн холбоо	358,146	242,615	115,531
15	Монголын урлагийн зөвлөл	172,762,441	362,801	535,564
16	Монголын тул сан	65,892	138,373	204,265
17	Монголын радио спортын холбоо ТББ	67,135	140,983	208,118
18	Бадамлянхуа хүүхдийн төв	26,434	55,511	81,945
19	Чөлөөт хэвлэл сан ТББ	2,336,283	4,906,193	7,242,476
20	Монголын теннисний холбоо	294,602	618,664	913,266
21	Монгол ви.и.ти.нет ТББ	23,108,324	48,721,930	71,830,253
22	Хустайн цогцолбор газар төв	4,030,808	8,464,696	12,495,504
23	Дэлхийн зөн ОУБ	237,767	499,310	30,749,377
24	Монголиан Азия Рийч	28,680	60,228	88,907
25	Олон улсын тахь групп	48,650	102,166	150,816

26	Хөгжил дэх оролцооны төлөөх холбоо	70,375	147,788	218,163
27	Дезерет ОУ-ын энэрэлийн байгууллага	28,095	58,999	87,094
28	Ворлд Вирнинг	42,896	92,181	136,077
29	Хүүхдийг Ивээх Сан	6,866,102	16,886,434	48,428,736
30	Хөгжлийн төлөө адал явдал ТББ	43,598,810	149,069,534	767,788,664
31	Ватиканы католик шашны байгууллага	539,560	1,133,076	1,672,636
32	CLAIM ТББ	2,371,986	4,981,170	7,353,156
33	GO HELP ТББ	2,970,859	7,454,652	22,584,000
34	Зэрлэг амьтныг хамгаалах нийгэмлэг	306,809	649,325	956,135
35	Францын тахь хамгаалах холбоо	43,423	91,188	134,611
36	Кама сервис интернешнл ТББ	719,996	1,511,992	2,231,988
37	Амийн мод сэргэлт төлөөлөгчийн газар	0	182,362	182,362
38	FIRE	91,295	191,720	283,015
39	Мерси Кор Интернешнэл	15,905	33,401	49,307
40	НЛМ-тусламжийн байгууллага	314,297	660,023	974,320
41	Кристина Нобелийн Хүүхдийн Сан	38,388	80,615	119,004
42	Комтех Солонгос Монголын харилцааг дэмжих нийгэмлэг	156,293	633,170	789,463
43	Уран хийц ТББ	26,626	55,915	82,541
44	Исүс христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм	8,700,803	18,271,686	26,972,489
45	Хамрын хийд	122,795	257,870	380,665
46	Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг	70,002	147,005	217,007
47	Монгол дах еховагийн гэрчүүдийн шашны нийгэмлэг	1,372,506	3,773,598	5,146,104
48	Монгол дах махаяна уламжлалыг хадгалах төв	257,830	812,140	3,776,950
49	Ариун бичээс нийгэмлэг	2,879,825	6,047,632	8,927,456
50	Зэрлэг амьтан судлах, хамгаалах төв	15,619	32,800	48,420
51	Хөгжлийн салхи нийгэмлэг	883,103	1,854,517	2,737,620
52	Монгол говийн хөгжил сан ТББ	995,780	2,091,139	3,086,919
53	Мэргэн бууч холбоо	721,168	1,514,453	2,235,621
54	Завхан аймгийн Цагаанчулуут сумын нутгийн зөвлөл	1,050,294	2,205,617	3,255,911
55	Смарт картын нэгдсэн холбоо	4,151,398	8,717,936	12,869,335
56	Монголын эспэрранто нийгэмлэг	11,583	24,325	35,908
57	Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо	1,458,874	3,063,636	4,522,510
58	Богдхан уулын байгалийн цогцолбор төв	0	1,753,025	1,753,025
59	Ирвэс хамгаалах сан	22,301	46,833	69,134
60	Манай гэр бүл нийгэмлэг ТББ	197,873	415,533	613,406
61	Марал-ганга ТББ	146,442	307,528	453,970
62	Чингэс хаан поло ба морь унуулах клуб	232,063	487,331	719,394

63	Baranes Yaig	487,516	2,077,871	13,106,267
64	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз	4,723,407	13,777,597	18,501,004
65	Хөүптаун	2,440,591	5,125,241	7,565,831
66	Хүүхдийн төлөө сайн дурын хайрын хишиг төв	869,027	1,824,956	2,693,982
67	Zhang and sheehan trading co ХХК	1,903,832	3,998,048	5,901,880
68	Бадмаараг хаш	2,720,410	5,712,862	8,433,272
69	Ли улаанцэцэг	7,406,990	15,554,678	22,961,668
70	Мал эмнэлэгийн хүрээлэн	285,378	599,294	884,672
71	Одон орон геофизикийн судалгааны төв	19,141,352	40,196,839	59,338,192
72	Хими, хими-технологийн хүрээлэн	83,010	174,321	257,331
73	Байгаль орчны мэдээллийн төв	477,363	1,002,467	1,479,832
74	Хурын шим төв	10,123,433	21,259,209	31,382,642
75	Геоэкологийн хүрээлэн	558,711	1,173,293	1,732,004
76	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	2,289,012	4,806,924	7,095,936
77	Физик, технологийн хүрээлэн ТББ	55,550	116,655	172,205
78	Хилийн цэргийн 0151-р анги	237,511	498,772	736,283
79	ШУА-ийн биологийн хүрээлэн	222,984	468,266	691,249
80	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	8,224	17,270	25,494
81	Иточу корпорацийн төлөөлөгчийн газар	92,661	194,589	287,250
82	Олон улсын сити байгууллагын төлөөлөгчийн газар	868,711	1,824,294	2,693,006
83	Монголын зүүний хүчний холбооны бид клуб	554,461	3,027,365	3,581,826
84	Тархсан монголчуудын нэгдэл нийгэмд үйлчилдэг ТББ	914,481	1,920,411	2,834,892
85	Тэнгэр өөд холбоо	0	0	0
86	Монголын цанын холбоо	8,596	18,051	26,646
87	Монголын практик бүүдлагын холбоо	457,581	960,920	1,418,500
88	Хүслийн хүч гишүүддээ үйлчилдэг ТББ	227,596	477,951	705,547
89	Ихмайдар сан ХХК	3,299,684	6,929,336	10,229,020
90	Монголын хөл бөмбөгийн холбоо ТББ	3,386,445	7,111,534	10,497,979
91	Талын шинэ нүүдэлчин ТББ	38,005	79,810	117,815
92	Монголын байгаль хамгааллын биологийн нийгэмлэг	270,817	568,715	839,532
93	Бэлчээрийн экологи, нийгэмд үйлчилдэг ТББ	337,063	707,832	1,044,894
	Нийт дүн	421,191,688	486,444,361	1,315,378,853

**БУСАД**



ТББ-үүд нийгэм, иргэдийн бүлгийн нийтлэг эрх ашиг, сайн сайхны төлөө хувь нэмэр оруулах зорилгодоо тууштай байж үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад санхүүгийн олон тулгуурт эх үүсвэртэй байх нь чухал нөхцөл болно. Мөн Монгол улсад филантропийн соёлыг иргэд, албан байгууллагуудын дунд түгээн сурталчлах, татварын бодлогоор хөхүүлэн дэмжих зэрэг санаачлагууд үгүйлэгдэж байна. Төрөөс үүнийг бүх талаар дэмжих бодлого баримтлах нь иргэний нийгмийн хөгжилд томоохон түлхэц болно.

2008 оны 5 сарын 8-ны өдрийн Нийгмийн даатгалын тухай хуулиар тус хуулийн 4 дүгээр зүйлийн 2.1-т “өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн гэрээгээр, эсхүл Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд зааснаар иргэнтэй байгуулсан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн” нийгмийн даатгалд заавал даатгуулна гэсэн нэмэлт өөрчлөлт хийсэн явдал ТББ-уудад том бэрхшээл учруулж байна. Учир нь ТББ-үүд үйл ажиллагаа явуулах санхүүгийн эх үүсвэр хязгаарлагдмал, тогтвортой бус байдгаас болж тэр болгон хөдөлмөрийн гэрээгээр буюу үндсэн ажилтан олноор ажилуулах боломжгүй байдаг. Тиймээс ТББ-үүд богино хугацааны гэрээгээр, эсвэл цагийн ажилтан авч ажилуулах тохиолдол түгээмэл байдаг. Тэгсэн хэдий ч ажил олгогчийн хувьд ТББ-үүд ажилуулсан хүмүүст олгосон аливаа төлбөр, урамшууллын 11 хувьтай тэнцэх хэмжээний нийгмийн даатгалын шимтгэл төлөх болсон. Мөн гэрээгээр ажиллаагүй сайн дурьханд ТББ-аас хоол, унааны зардал олгосон тохиолдолд ч хуульд заасан 11 хувийн шимтгэл төлөх шаардлага тавигддаг. Нийгмийн даатгалын шимтгэл дутуу төлсөн шалтгаанаар торгууль хүлээсэн ТББ тоо олон байна.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ) болон Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-оос нэмэлт мэдээлэл болгож авсан ТББ-ын бүртгэл болон үйл ажиллагаатай холбогдолтой мэдээллийг судлаж үзэхэд Татварын ерөнхий газар (ТЕГ), УБЕГ болон ҮСХ-ны тоон мэдээллүүд зөрөх, ТББ-ыг бүртгэх үйл явц нь нэгдсэн стандарт жишиггүй, байгууллага тус бүр янз бүрээр ойлгож өөр өөрийн үзэмжээр бүртгэдэг явдал харагдлаа. Энэ нь ТББ-ын бүртгэлийг цэгцлэх, мөн ангиллын нэгдсэн стандартыг холбогдох төрийн бүх байгууллагуудаар жигд мөрдүүлэх шаардлага тулгамдаж байгааг харуулж байна. Татвар төлөгч ТББ-ын хэлбэрээр сургууль, цэцэрлэг, сонин, радио, телевиз зэрэг ашгийн төлөө байгууллагууд бүртгэгдсэнээс гадна эрх барьж байсан болон одоо ч засгийн эрхэд байгаа улс төрийн намууд мөн ТББ-ын хэлбэрээр ажиллаж байна. Энэ бүгд ТЕГ, УБЕГ, ҮСХ дахь ТББ-ын бүртгэлийн тогтолцоог сайжруулах шаардлагатайг дахин нотолж байна /доорх Хүснэгт 13-ыг үзнэ үү/.

**Хүснэгт 13. Улсын бүртгэлд ТББ-ын ангиллаар бүртгэгдсэн байгууллагын тоо**  
/ 2011 оны байдлаар/

Байгууллага /ангиллаар/	ТЕГ	УБЕГ	ҮСХ
Олон нийтийн байгууллага	1.138		
Сан	158	480	
ТББ	2.033		
Шашны байгууллага	343	233	
Гишүүдэд үйлчилдэг ТББ		838	1.464
Нийгэмд үйлчилдэг ТББ		5.004	4.427
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл		486	
Үйлдвэрчний байгууллага		292	
<b>Нийт дүн</b>	<b>3.672</b>	<b>7.333</b>	<b>5.891</b>

“ТББ-ын татварын өнөөгийн байдал” судалгааны үр дүнд дараах дүгнэлтийг хийж холбогдох арга хэмжээ авч ажиллах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

**Дүгнэлт 1:** Өнөөг хүртэл ТББ-уудыг холбоо, сан, нийгэмд үйлчилдэг, гишүүддээ үйлчилдэг гэж ангилж ирсэн ба энэ ангиллыг Татварын ерөнхий газар, харъяа татварын албад, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Үндэсний статистикийн хорооны ТББ-ын бүртгэл, мэдээлэлд янз бүрээр тусгагдсан байдал харуулж байна<sup>2</sup>.

Шийдвэрлэх санал:

Иймээс юуны өмнө ТББ-ын ангиллыг олон улсын стандартад нийцүүлэн сайжруулж, ТББ-ын бүртгэлийг цэгцлэх, мөн ангиллын нэгдсэн стандартыг холбогдох төрийн бүх байгууллагуудаар жигд мөрдүүлэх.

- Төрийн бус байгууллагын ангиллыг АШГИЙН ТӨЛӨӨ БУС БАЙГУУЛЛАГЫН ОЛОН УЛСЫН АНГИЛАЛ /International classification of non-profit organizations–ICNPO/ болон ISIC-ын дагуу гаргах.
- Төрийн бус байгууллагын бүртгэлийг шинэчилсэн ангиллын дагуу бүртгэж Улсын бүртгэлийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо болон Татварын ерөнхий газар, харъяа татварын албадаар нэгэн жигд мөрдүүлэхийг холбогдох хууль тогтоомжоор баталгаажуулах.
- Төрийн бус байгууллагын статистик мэдээллийн хамралт, үзүүлэлтийн системийг боловсронгуй болгох, дагавар данс байгуулах ажлыг Үндэсний Статистикийн Хороо АНУ-ын Жонс Хопкинсийн их сургуультай хамтран хийх. Уг үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, мэдээллийн нэгдсэн тогтолцоо бий болгох ажлын хэсэгт ТББ-ын төлөөллийг оролцуулан ажиллуулах.

**Дүгнэлт 2:** 2007 оноос өмнө мөрдөгдөж байсан “Аж ахуйн нэгж, байгууллагын албан татварын тухай” хуульд төрийн бус байгууллага нь татвар төлөгч бөгөөд уг хуулийн 7.1.7-д “нийгэмд үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагын орлогыг албан татвараас чөлөөлнө”, мөн 7.1.2-т “төрийн бус байгууллагын гишүүд, дэмжигчдийн татвар, хандивыг албан татвараас чөлөөлнө” гэж тус тус заасан байсан юм. 2006 оны 6 дугаар сард батлагдсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар ТББ-ыг татвар төлөгчийн жагсаалтаас хасаж дээрх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалтуудыг бүгдийг нь хассан юм. Мөн түүнчлэн хуулийн этгээдээс ТББ-д өгсөн хандивыг татвараас чөлөөлөлдөг заалт 1997 оны хуулиар батлагдсан байсныг УИХ-аас 1999 онд Татварын хуулиудад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөр энэ заалтыг хүчингүй болгосон юм. Ингэснээр ТББ-ын мөн чанар болсон нийтэд ач тустай үйл ажиллагаа явуулах гэсэн үзэл баримтлалыг алга хийж, ТББ-уудыг бусад аж ахуйн нэгж байгууллагуудаас ялгарахгүй болгож, улмаар ТББ-ын статусаар ашиг олох, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд олширсон нь үүнийг нотолж байгаа юм.

Шийдвэрлэх санал:

- Нийтэд ач тустай үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын орлогыг татвараас чөлөөлөх. Өөрөөр хэлбэл, 2007 оноос өмнө үйлчилж байсан “Аж ахуйн нэгж, байгууллагын албан татварын тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-р заалтыг эргүүлэн тусгах.
- Нийтэд ач тустай үйл ажиллагааны тухай хуулийн төсөл болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нийтэд ач тустай үйл ажиллагаа

<sup>2</sup> “Төрийн бус байгууллагын татварын орчны өнөөгийн байдал” судалгаа, ДЕМО, 2012

явуулдаг ТББ-д хуулийн этгээдээс өгсөн хандивыг татвар ногдох орлогоос хасч татварын хөнгөлөлт үзүүлэх заалт оруулах.

**Дүгнэлт 3:** ТББ-ын санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүднээс ТББ-уудад олон тулгуурт санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх нь чухал болоод байна.

Шийдвэрлэх санал:

- ТББ нь өөрийн үндсэн үйл ажиллагаанаас гадна аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж болох бөгөөд үүнээс олох орлогыг дүрэмдээ заасан зорилгодоо зарцуулах ёстой. Энэ орлого нь татвараас чөлөөлөгдөх бөгөөд харин дүрэмдээ заасан зорилгоос өөрөөр зарцуулвал бусад аж ахуйн нэгжүүдийн адил орлогын албан татвар төлдөг байх.
- Хувь хүний орлогын албан татварын хуульд “МУ-д оршин суугч татвар төлөгч нь ХХОАТ-ын хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан орлогод ногдох жилийн татвараас 1%-тай тэнцэх татварыг нийтэд ач тустай үйл ажиллагаа явуулдаг аль нэгэн ТББ-д шилжүүлүүлэхээр тусгайлан нэр зааж тодорхойлно” гэсэн заалтыг нэмэж оруулах.
- Нийтэд ач тустай үйл ажиллагааны тухай хуулийн төсөлд Иргэний нийгмийн хөгжлийн сан байгуулах заалтыг оруулж, уул уурхайн ашиг орлого, худалдан авах ажиллагааны тендерийн тодорхой хувь, ХХОАТ-ын 1 хувийн хуваарилагдаагүй татварын дүн зэрэг олон талт эх үүсвэрээс бүрдүүлэхийг захиран зарцуулах механизмын хамт тодорхойлон тусгах.
- 2008 оны Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2.1-т нэмэгдэж орсон заалтыг хүчингүй болгох, эсвэл ТББ-уудад хамааралгүй болгох.

**ХАВСРАЛТ**